

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАНД
ОРУУЛАХ УЛСЫН КОМИССЫН АКТ

ДКБ, оны 22 сарын 29 өдөр

Дугаар 4006 /2011-

Улаанбаатар хот

НЭГ.

- 1 Карилга байгууламжийн нэр, байршил, хүчин чадал *СГ Дуртлан 2-р хороо*
ХХК-ийн байршил, 200м бүрэлдэх барилга нь
төхиддэг. 1992 (1992.12.29) үйлдвэрийн дотоодын дахиадсан
12м (3) гарал-н дахтар шигшэр баригдаж барилга нь
- 2 Хяналтагч, ашиглагч байгууллага, аж ахуйн нэгж *ХХК*
- 3 1 рөнхий ба туслан гүйцэтгэгч байгууллага, аж ахуйн нэгж *Сүхбаатар аймгийн "Монгол" ХХК*
- 4 Нураг төсөв боловсруулсан байгууллага, аж ахуйн нэгж *"Амжилт" ХХК*
"Амжилт" Т. Бадраа, "Эн. Энх-Бич" ХХК зохион С. Чойруу
- 5 Энэхүү барилга байгууламжийг *ХХК-ийн дахиадсан 163 тоот*
түгчаацаар төхиддөгсөн
- нийдвэрээр зохион байгуулсан 20 хүний бүрэлдэхүүнтэй улсын комисс нь уг барилга
 байгууллагын байршил, ашиглалтанд зориулах *Төмөр 1233 байрлал*
 байгууллагын 2006 оны 11 сарын 28 өдрийн 28 тоот мэдэгдлийн дагуу 2006 оны
 12 сарын 13 өдрөөс 1 өдөрт багтаан шинээр барьсан, өргөтгөл шинэчлэлт, их засварын
 ажил холбогдох акт баримтуудтай танилцаад газар дээр нь шалган үзэв.
- 6 Энэ барилга байгууламжийг *001* дугаартай зураг, төслөөр *2006* оны 07 сараас барьж
 эхэлсэн ба *2006* оны 11 сарын 28 өдөр барьж дууссан байна.


XOËP.

- Энэхүү ... *ХХ Хагсаны Гүйцэтгэл - Зочиг бүртгэл - 6 н*
барилга байгууламж, холбогдох акт баримтуудыг шалгахад ашиглалтанд оруулах тухай
улсын комиссоос ШИЙДВЭРЛЭСЭН нь:
*Зурган гишээний 2007 оны 7-р сарын 1-
нийн 3 дугаар орох газраар өгө олгох,
догоо 2007 оны 11-дм болон 1 м 43 х.*
- Энэхүү барилга байгууламж нь зураг төслийн дагуу бүрэн хийгдэж
гүйцэтгэл - зочиг бүртгэл зориулалтаар ашиглахад *Хамагдалынхаа* гэж
үзээд ашиглагч /захиалагч/ байгууллага болох *ХХК - нв* мэдэлд
2006 оны 12 сарын 29 өдрөөс ашиглалт /үйлдвэрлэл үйлчилгээ, оршин суух зэрэг/
явуулахыг зөвшөөрөв.
- Улсын комиссоос даалгах нь:
- Гүйцэтгэгч байгууллагад:
Барилга байгууламжийн ашиглалтанд оруулах улсын комиссын акт, холбогдох
баримтуудын эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч байгууллагад 3 хоногийн дотор багтаан шилжүүлэх.
 - Ашиглагч /захиалагч/ байгууллагад:
А/ Үл хөдлөх хөрөнгийн албанд барилга байгууламжийг 7 хоногийн дотор багтаан бүртгүүлэх.
Б/ Барилга байгууламжийн ашиглалтын дүрмийн дагуу барилга байгууламжийн хувийн хэргийг нээж, баяжилт хийж байх.
В/ Барилга ашиглалтын дүрмийн дагуу барилгын хэвийн ашиглалтыг явуулж, засвар арчлалтыг тогтоосон хугацаанд тогтмол хийж байх.

2.4 Улсын комиссын акт 3 хуудас, хуралдааны тэмдэглэл 6 хуудас, улсын комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт 6 хуудас материал, барилга, байгууламжийн баримт бичгийн жагсаалтыг хавсаргас.


ХХК-ийн үйлчлэл зочид буудлын
Улсын комиссын бүрэлдэхүүн

Комиссын дарга: УМХГ-ын Барилга техникийн хяналтын улсын ахлах байцаагч




А. Мягмаржав

Комиссын н/б дарга: БХХ трейд ХХК-ийн захирагч, захиалагч



Ч. Эрдэнэчимэг

Комиссын гишүүд: УМХГ-ын Барилга техникийн хяналтын улсын ахлах байцаагч



И. Очирбат

УМХГ-ын эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагч




Х.Авирмэд

ОБЕГ-ын барилгын техникийн хяналт хариуцсан ахлах

мэргэжилтэн 8/2/18. 2006.12.28 Ч. Ганболд

УМХГ-ын Монголын харилцаа холбооны улсын ахлах

байцаагч



Ж. Наранцэцэг

УМХГ-ын хот байгуулалтын хяналтын улсын ахлах байцаагч



О. Мөнхжаргал


УМХГ-ын Эрүүл ахуйн хяналтын улсын ахлах байцаагч



Ш. Уранцэцэг

УМХГ-ын барилгын техникийн хяналтын улсын ахлах

байцаагч



Д. Санжмятав

УМХГ-ын байгаль орчин, геодезийн зураг зүйн хяналтын

улсын ахлах байцаагч




Я. Жамъян

УБДС ХК-ийн ерөнхий инженер



Ш. Мөнхжаргал

УБЦТС ХК-ийн хэлтсийн дарга



Г. Базаргүр

Арткон зураг төслийн компани, зургийн автор

2/02 2006

Б. Баяраа

Эл энд Эйч зураг төслийн компани, зургийн конструктор

Инженер



С. Чулуун


УСУГ-ын газрын хэсгийн менежер



Ё. Сүрэнхорлоо

МЦХ ХК-ийн

ХБАГ-ын ерөнхий инженер



Т. Түрвэсүрэн

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАРТ

Хүсэлтт гаргах нь

Манай компани нь Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 10-р хорооны нутагт Зочид буудал, рестароны чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар холбогдох норм стандартын дагуу 2 давхар байшин барьж, тохижуулан ашиглалтанд оруулахад бэлэн болоод байна.

Манай компанийн тус объектонд Зочид буудалын үйл ажиллагаа эрхлэн явуулах зохих зөвшөөрөлийг олгоно үү.



Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2012 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн
29 дүгээр тушаалын 4 дүгээр хавсралт



АЖЛЫН БАЙРНЫ ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ДҮГНЭЛТ

Дугаар **№ 0002790**

Аж ахуйн нэгж, байгууллагын нэр:

Хаяг: **БЗД-ийн 25-р хороо** **7007**

Ажлын байрны зориулалт, үйл ажиллагааны чиглэл:

..... **ДЭН БУУДАА**

Барилга байгууламжид гал унтраах тоног төхөөрөмж, /гал унтраах автомат болон
дохиоллын систем, утаа зайлуулах систем, усан хангамж/ анхан шатны багаж хэрэгсэл,
бодис материал зэргийг байрнуулан ашиглахад энэхүү дүгнэлтийг олгоно.

/Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 33.1.4/

/Галын аюулгүй байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.7./

Олгосон: **2012 он 04 сар 13 өдөр**

Хүчинтэй хугацаа: **2014 он 04 сар 12 өдөр** хүртэл.

Дүгнэлт олгосон:

..... **Баянзүрх Ачират** аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар/хэлтсийн/
дарга **Хурандаа** цолтой **М.Басалжаргал Ганзоригт**

Дүгнэлт гаргасон:

..... **Баянзүрх Ачират** аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар/хэлтсийн/
Гал түймрийн улсын хяналтын байцаагч * **Хөдөөч** цолтой **А.Агваа Ж.Харгалсайхан**



НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2011 оны 07 сарын 20 өдөр

дугаар 120

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, 25 дугаар зүйлийн 25.1 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2011 оны 1/1089 тоот албан бичгээр өргөн барьсан саналыг үндэслэн Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам"-ыг шинэчлэн хавсралт ёсоор баталсугай.

Хоёр. Журмын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч /Г.Мөнхбаяр/-д даалгасугай.

Гурав. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2006 оны 138 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт жуулчны бааз, амралтын газар, зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх журам" болон 2010 оны 198 дугаар тогтоолоор батлагдсан "Нийслэлийн худалдаа, үйлчилгээний нийтлэг журам"-ын 4.13 дахь заалтын "дэн буудал" гэснийг хүчингүй болсонд тус тус тооцсугай.

ДАРГА

Т.БИЛЭГТ

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120
дугаар тогтоолын хавсралт

УЛААНБААТАР ХОТЫН НУТАГ ДЭВСГЭРТ
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БАЙР СУУЦНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт Аялал жуулчлалын байр сууц /Амралтын газар /resort complex/, Жуулчны бааз /tourist camp/, Гэр буудал /Ger hotel/, Сувилалын газар /spa hotel/, Амралтын буудал /resort hotel, /Зочид буудал /hotel/, Дэн буудал /guest house/, Нийтийн буудал /hostel/, Авто буудал /motel/-ын үйл ажиллагаа эрхлэх явцад үүсэх харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

Хоёр. Нэр томъёоны ойлголт

2.1. Амралтын газар /resort complex/ гэдэгт байгалийн нөөцөд түшиглэн байгуулсан, байнгын үйл ажиллагаатай, байр хоол болон нэмэлт үйлчилгээ үзүүлэх, байр сууцны төрлүүдийн хосолмол хэлбэр бүхий байгууламжийг ойлгоно.

2.2. Жуулчны бааз /tourist camp/ гэдэгт байгалийн нөөцөд түшиглэн байгуулсан, улирлын үйл ажиллагаатай, байр хоол болон нэмэлт үйлчилгээ үзүүлэх байгууламжийг ойлгоно.

2.3. Гэр буудал /Ger hotel/ гэдэгт Монгол үндэсний хэв шинжийг хадгалсан, соёл, түүх, нүүдэлчдийн амьдралыг харуулсан бүтээгдэхүүнийг үзүүлэх байр, хоол зэрэг хязгаарлагдмал үйлчилгээ бүхий байгууламжийг ойлгоно.

2.4. Сувилалын газар /spa hotel/ гэдэгт эмчилгээ сувилгааны үйл ажиллагаа эрхлэн явуулах, байр, хоол болон нэмэлт үйлчилгээ үзүүлэх үйлчилгээний байгууламжийг ойлгоно.

2.5. Зочид буудал /hotel/ гэдэгт байр, хоолны үйлчилгээ үзүүлэх нэмэлт тоноглолтой, тусгай төрөлжсөн албад бүхий үйлчилгээний байгууламжийг ойлгоно.

2.6. Дэн буудал /guest house/ гэдэгт төв суурин газарт байрласан, байр, өглөөний хоол бүхий хязгаарлагдмал үйлчилгээний байгууламжийг ойлгоно.

2.7. Нийтийн буудал /hostel/ гэдэгт байр, хоол зэрэг хязгаарлагдмал үйлчилгээтэй, олноор байрлах хямд үнэтэй үйлчилгээний байгууламжийг ойлгоно.

2.8. Авто буудал /motel/ гэдэгт олон улсын болон улсын чанартай зам дагуу байрласан, байр, хоолны үйлчилгээ болон тээврийн хэрэгслэлд техникийн засвар үйлчилгээг үзүүлэх зориулалт бүхий байгууламжийг ойлгоно.

Гурав. Хамрах хүрээ

3.1. Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа дотоод, гадаадын өмчийн бүх хэлбэрийн аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэж байгаа газрууд энэхүү журмыг дагаж мөрдөнө.

3.2. Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт байгаа тусгай хамгаалалттай газар нутагт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэж байгаа байгууллагууд мөн энэхүү журмын дагуу ажиллана.

Дөрөв. Аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах шаардлага

4.1. Зочид буудал, дэн буудал, нийтийн буудал, авто буудлын үйл ажиллагаа эрхлэгч нь дараах шаардлагыг хангасан нөхцөлд ажил үйлчилгээ эрхлэнэ.

4.1.1 Хуулийн этгээд байна;

4.1.2. Тухайн ажлын байр нь оноосон нэртэй байх бөгөөд бусад газруудтай давхцахгүй байна;

4.1.3. Эрх бүхий байгууллагын шаардлагад нийцэхүйц тохижилт, хаягтай байна;

4.1.4. Тухайн төрлийн үйлчилгээний чанарын зэрэглэл үндсэн шаардлага, стандартыг 90-ээс доошгүй хувиар хангасан байна;

4.1.5. Тухайн төрлийн үйлчилгээний чиглэлээр мэргэжил эзэмшсэн, мэргэшүүлэх сургалтанд хамрагдаж үнэмлэх, гэрчилгээ авсан менежер, техникийн ажилтан, мэргэжлийн ажилчдаар хангагдсан байна;

4.1.6. Галын аюулгүй ажиллагааны шаардлага хангасан байна;

4.1.7. Үйлчилгээ явуулах барилга, байгууламжийг баталгаажсан зураг төслийн дагуу барьж улсын комисст хүлээлгэж өгсөн байна;

4.2. Амралтын газар, жуулчны бааз, сувилалын амралт, гэр буудлын үйл ажиллагаа эрхлэгч нь дараах шаардлагыг хангасан нөхцөлд үйлчилгээ эрхлэнэ.

4.2.1. Оноосон нэртэй байх бөгөөд бусад газруудтай давхцахгүй байна;

4.2.2. Эрх бүхий байгууллагын шаардлагад нийцэхүйц тохижилт, шаардлагад нийцсэн хаягтай байна;

4.2.3. Газар эзэмших болон байгаль орчны тухай хууль тогтоомжинд заасан шаардлагуудыг хангасан байна;

4.2.4. Тухайн төрлийн үйлчилгээний үндсэн шаардлага, стандартыг 90-ээс доошгүй хувиар хангасан байна;

4.2.5. Үйлчилгээ явуулах барилга, байгууламжийн зураг төсөлд баталгаажилт хийлгэж, улсын комисст хүлээлгэж өгсөн байна;

4.2.6. Аялал жуулчлалын болон зочид буудлын менежмент, маркетингийн мэргэжлээр мэргэшүүлэх сургалтанд хамрагдаж, үнэмлэх, гэрчилгээ авсан менежер, техникийн ажилтан, мэргэжлийн ажилчдаар хангагдсан байна.

4.2.7. Галын аюулгүй ажиллагааны шаардлага хангасан байна.

Тав. Үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл

5.1. Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт, аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэхэд Нийслэлийн Аялал жуулчлалын газраас зөвшөөрөл өгч гэрчилгээ олгоно.

5.2. Энэхүү журмын 4.1, 4.2-д заасан шаардлагыг хангасан аж ахуй нэгж байгууллагад зөвшөөрлийг олгоно.

5.3. Үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг тухайн ажлын байранд үйлчлүүлэгчдэд харагдахуйц газарт эх хувиар нь байрлуулна.

Зургаа. Зөвшөөрөл олгох

6.1. Аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүсэгч нь зөвшөөрөл авах хүсэлтээ Нийслэлийн аялал жуулчлалын газарт албан бичгээр гаргах буюу цахим сүлжээгээр ирүүлж болно.

6.2. Амралтын буудал, зочид буудал, дэн буудал, нийтийн буудал, авто буудлын зөвшөөрөл авахыг хүссэн албан бичиг /эрхлэх үйл ажиллагааны төрөл, оноосон нэр, оршин байрлах хаяг, харилцах утас, цахим сүлжээний хаягийг тодорхой бичих/-т дараах баримт бичгийг хавсаргана.

6.2.1. Зөвшөөрөл хүсэгч аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, иргэн бол иргэний үнэмлэхийн хуулбар;

6.2.2. Үйлчилгээний байгууламжууд нь эрүүл ахуйн нөхцлийг хэрхэн хангаж байгаа тухай мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлт;

6.2.3. Үйлчилгээний барилга байгууламжуудыг ашиглалтанд хүлээн авсан тухай улсын комиссын акт;

6.2.4. Галын аюулгүй байдлын талаарх онцгой байдлын газрын дүгнэлт;

6.2.5. Тухайн байгууламжийн гадна, дотор тал өрөөнүүд, үйлчилгээний заал талбай, хаяг тохижилтийг харуулсан фото зургийг хэвлэмэл болон файл хэлбэрээр;

6.2.6. Орон сууцны зориулалттай байранд үйл ажиллагаа явуулах бол тухайн байрны сууц өмчлөгчдийн холбооноос үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрсөн албан бичиг, оршин суугчдын зөвшөөрсөн гарын үсэг;

6.3. Амралтын газар, жуулчны бааз, сувилалын амралт, гэр буудлын зөвшөөрөл авахыг хүссэн албан бичиг /эрхлэх үйл ажиллагааны төрөл, оноосон нэр, оршин байрлах хаяг, харилцах утас, цахим сүлжээний хаягийг тодорхой бичих/-т дараах баримт бичгийг хавсаргана.

6.3.1. Зөвшөөрөл хүсэгч аж ахуй нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, иргэн бол иргэний үнэмлэхийн хуулбар;

6.3.2. Газар эзэмших эрхийн актийн баталгаажсан хуулбар;

6.3.3. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ;

6.3.4. Үйлчилгээний байгууламжууд нь үйлчилгээний эрүүл ахуйн нөхцлийг хэрхэн хангаж байгаа тухай мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлт;

6.3.5. Үйлчилгээний байгууламжуудыг ашиглалтанд хүлээн авсан тухай улсын комиссын акт;

6.3.6. Галын аюулгүй байдлын талаарх онцгой байдлын газрын дүгнэлт;

6.3.7. Тухайн байгууламжийн гадна, дотор тал өрөөнүүд, үйлчилгээний заал талбай, хаяг тохижилтийг харуулсан фото зургыг хэвлэмэл болон файл хэлбэрээр;

6.4. Зөвшөөрөл олгогч нь зөвшөөрөл авахыг хүссэн аж ахуй нэгжийн албан бичиг, хавсаргасан баримтуудыг хүлээн авч хянан үзэж энэхүү журамд заасан шаардлагыг хангасан эсэхийг тогтооно.

6.5. Зөвшөөрөл олгогч нь хүсэлт гаргасан байгууллагуудын талаар цагдаагийн газар болон холбогдох бусад байгууллагуудаас ирүүлсэн мэдээллийг харгалзан үзнэ.

6.6. Зөвшөөрлийг нэг жилийн хугацаагаар олгоно.

6.7. Зөвшөөрөл олгогч нь хүсэлтийг хүлээн авсанаас хойш ажлын 15 өдрийн дотор зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэнэ.

6.8. Зөвшөөрөл олгосон шийдвэр гарсанаас хойш 7 хоногийн дотор жагсаалтыг харьяа дүүргийн Засаг даргын тамгын газар, цагдаагийн байгууллага, мэргэжлийн хяналтын байгууллагад хүргүүлнэ.

6.9. Зөвшөөрөл олгохоос татгалзсан бол үндэслэлийг тодорхой зааж, бичгээр хариу өгнө.

6.10. Албан бичигт хавсаргасан баримт бичиг нь шийдвэр гаргах шаардлагыг хангаагүй бол дахин тодруулах буюу нэмэгдэл материал гаргуулахаар зөвшөөрөл хүсэгчид буцаана.

6.11. Зөвшөөрөл олгохтой холбогдон гарах унааны зардал болон гэрчилгээ бичиг хэргийн зардал 5000 төгрөгийг зөвшөөрөл хүсэгч тал хариуцна.

Долоо. Зөвшөөрлийг сунгах, цуцлах

7.1. Аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаагаар сунгана.

7.2. Зөвшөөрлийн хугацаа дуусахаас 30-аас доошгүй хоногийн өмнө сунгуулах хүсэлтээ зөвшөөрөл эзэмшигчээс гаргана.

7.3. Зөвшөөрлийг сунгуулах тухай хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор шийдвэрлэнэ.

7.4. Зөвшөөрөл нь олгосон өдрөөс эхлэн заасан хугацаанд хүчинтэй байх бөгөөд эзэмшигчээс түүний хугацаа дуусахад сунгуулах тухай өргөдөл гаргаагүй бол анх товлосон он, сар, өдрийн дараагийн ажлын өдөр болмогц дуусгавар болно.

7.5. Зөвшөөрлийн хугацааг сунгахад мэргэжлийн хяналтын байцаагчийн ажлын байрны эрүүл ахуйн дүгнэлтийг үндэслэнэ.

7.6. Зөвшөөрөл эзэмшигч нь шаардлага хангахгүй үйл ажиллагаа явуулж байгаа нь тогтоогдвол хууль хяналтын байгууллага, мэргэжлийн хяналтын улсын байцаагчаас аялал жуулчлалын байр сууцны ажил үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийг түр хугацаагаар буюу бүрэн зогсоох тухай асуудлыг зөвшөөрөл олгогчид бичгээр тавина.

7.7. Зөвшөөрөл олгогч нь дараах тохиолдолд зөвшөөрлийг хугацаанаас нь өмнө цуцлана.

7.7.1. Хуулийн этгээд татан буугдсан;

7.7.2. Зөвшөөрөлд заасан ажил үйлчилгээг нэг жилийн хугацаанд эрхлээгүй;

7.7.3. Нийгэм, иргэд, үйлчлүүлэгчдийн эрх ашиг, эрүүл мэнд, аюулгүй байдалд харшилсан ажил үйлчилгээ явуулсан болох нь тогтоогдсон;

7.7.4. Хууль тогтоомжид заасан бусад үндэслэл бүрдсэн;

Найм. Аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэхэд хориглох зүйлс

8.1. Зөвшөөрлийг өөр аж ахуй нэгжид шилжүүлэн хэрэглэх, өөр ажлын байранд ашиглах, арилжааг;ах;

8.2. Согтууруулах ундаа худалдаалах, түүгээр үйлчлэх явцад үйлчилгээний дэг журамд онцгой анхаарч, хуульд заасан цагийн хуваарийг баримтлан согтуу хүн, 21 нас хүрээгүй хүнд үйлчлэх;

8.3. Биеэ үнэлэх явдлыг дэмжсэн, байраар хангасан, зуучилсан, сурталчлах, зохион байгуулалтайгаар оролцох, гэмт хэрэг зөрчил гаргах нөхцөл бүрдүүлэх;

8.4. Хуулиар хориглосон бусад үйл ажиллагаа;

Ес. Байгууллага аж ахуй нэгжийн эрх, үүрэг

9.1. Үйл ажиллагаандаа Монгол улсын хууль тогтоомж эрх бүхий байгууллагаас гаргасан журам заавар, шийдвэрийг хэрэгжүүлж ажиллана.

9.2. Эрх бүхий байгууллагаас гаргасан загварын дагуу өөрийн үйл ажиллагааны талаарх тайлан мэдээг тухайн цаг хугацаанд нь гаргаж ирүүлнэ.

9.3. Зөвшөөрөл эзэмшигч өөрийн эрх ашиг хөндөгдсөн тохиолдолд хууль хяналтын байгууллагад хүсэлтээ тавьж шийдвэрлүүлэх эрхтэй

Арав. Хяналт, хариуцлага

10.1. Зөвшөөрөл авсан жуулчны бааз, амралтын газар, зочид буудлын үйл ажиллагаанд нийслэл, дүүргийн төр захиргааны болон хууль хяналтын байгууллагууд эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт тавьж журмын хэрэгжилтийг хангаж ажиллана.

10.2. Аялал жуулчлалын байр сууцны ажил үйлчилгээ эрхлэх явцдаа гаргасан зөрчилд Монгол улсын хууль, тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

10.3. Хууль, тогтоомж болон энэхүү журмыг зөрчсөн байгууллага, иргэнд эрх бүхий албан тушаалтан, улсын байцаагчид хууль, журмын дагуу хариуцлага хүлээлгэнэ.

10.4. Энэхүү журмын 7.8-д заасан нөхцөл үүссэн тохиолдолд зөвшөөрөл олгогч зөвшөөрлийг цуцлах буюу хураана.

10.5. Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт Аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагааг зөвшөөрөлгүй эрхэлсэн, энэхүү журмыг зөрчсөн тохиолдолд нийслэл хотын хангамж үйлчилгээ үзүүлэхгүй бөгөөд түүнээс үүсэн гарах хохирлыг тухайн этгээд хариуцна.

Вийсгийн агай тухайлаган газар
оргоды гаргаж ухуул.

Авсгийн . 1 миний бие нь

Б.З. дүүргийн хорооноос 100 дугуйн 40 мянгуу
" нэрлэв Дэн Бүүрэн үл амьтлаа
эргэлдэ билээ. Тус дүүргийн Сметой байрлан
газар, Үндэсний үлэмжтэй аайн, Мэргэлийн
малын дэргэ байгууллагаас зохих шалхыг
мэргэжлээрээ үрн үл амьтлаахтай
Тамхиаан зохих үрнээ дүржлийн олсон билээ.
Мийнх, нагай дэн Бүүрэн амьтлуулж зовиовоо.
Олон агай үү.

Оргоды гаргасан.

2013.3.15

Чинэс



МОНГОЛ УЛСЫН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧИЙН ДҮГНЭЛТ

211239 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Хувьсгалчдын өргөн чөлөө-15, Төр захиргааны II байр
И-мэйл: ub_info@inspection.gov.mn,
Утас: 70111284, Факс: 31-13-77

№

Барилгын ашиглалт, хийцийн
төлөв байдлын тухай

Баянзүрх дүүргийн 10 дугаар хорооны нутаг дэвсгэр,
ий эзэмшил хашааны урд талд орон сууцны зориулалтаар баригдан ашиглагдаж
байгаа барилгын төлөв байдалд 2012 оны 12 дугаар сарын 25-ны өдөр иргэн
байлчлуулан шалгалт хийлээ.

Иргэн өөрийн гэр бүлийн хамтын хэрэгцээний зориулалтаар
660 м² газрыг 2012 оны 09 дүгээр сарын 13-ны өдөр дугаартай
гэрчилгээгээр өмчилж авсан газар дээр тус барилгыг барьсан байна.

Энэхүү барилга нь цутгамал төмөр бетон баганан суурь, каркасан
бүтээцтэй, гадна талаараа тортой шавардлагатай дулаалгын хөөсөнцөр бүхий
тоосгон ханатай, цутгамал төмөр бетон хучилттай, 2 үе уур тусгаарлагч, 3 үе РЧ-
350 маркийн хар цаас, РК-420 маркийн 1 үе хуягт хар цаасан хучлагатай хавтгай
дээвэртэй, тэнхлэгээрээ 19.2x12.0 м хэмжээтэй, зоорьтой, 2 давхар, холбогдох
байгууллагын зөвшөөрлийн үндсэн дээр цахилгааны шугам сүлжээнд холбогдсон,
нам даралтын тогоо бүхий халаалттай, угсралтыг "Бериллбилд" ХХК гүйцэтгэсэн
байна.

Шалгахад барилгын үндсэн хийц, бүтээцэд эвдрэл, гэмтэл илрээгүй,
стандартын шаардлага хангасан барилгын материалаар барьсан байна.

Дээрх байдлыг үндэслэн ДҮГНЭХ нь:

Энэхүү барилгын ашиглалт нь Засгийн газрын 2009 оны 72 дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт болох "Барилгын ашиглалтын дүрэм"-ийн 2.2.1 /хүний
эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцөл бүрдүүлэх/ дэх заалтын
шаардлагыг хангаж байна.

Цаашид барилгад эвдрэл, гэмтэл илэрсэн тохиолдолд засварлах арга
хэмжээг хууль, дүрэм журамд заасны дагуу авах нь зүйтэй.

БАРИЛГЫН ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ Б.ЭРДЭНЭСҮРЭН

011105025899



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР
ULAANBAATAR CITY TOURISM DEPARTMENT

ЗӨВШӨӨРӨЛ

LICENSE

№: 13144

Дүүргэл	Баянзүрх	DISTRICT	Bayanzurkh
Хороо	25-р хороо	SUBDISTRICT	25 th
Хял агуулан нэрлэсэн нэр	----	CORPORATE NAME	----
Засгийн нэр	Б.Отгон	OWNER/DIRECTOR	Otgon,B
Үйлчилгээний төрөл	Дан буудал	BUSINESS ACTIVITY	Guest house
Огноосон нэр	Мая хотол	PROPER NAME	My hotel
Байршал	АОС 40	LOCATION	AOC 40
Хугацаа	Нэг жил	EXPIRY DATE	One year

MNS 5738:2007

стандартын шаардлагаг хангасан тул

This is to certify that

Otgon,B

has been certified

Б.Отгон

д. урт дэглэмд

is meeting the requirements of the
standard.

MNS 5738:2007

догол зөвшөөрөл олгов.

ДАРГА
DIRECTOR

Э.БАТТУЛГА
E.BATTULGA

ОЛГОСОН / DATE OF ISSUE

2013.11.03 / .28/